БАЯНХОНГОР АЙМГИЙН “ТЕЛЕ КАМЕРИЙН ХЯНАЛТЫН ДЭД ТӨВ”-Д ВИДЕО УДИРДЛАГЫН СИСТЕМ НЭВТРҮҮЛЭХ ШААРДЛАГА, ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2025 оны 04 дүгээр сарын 08

ГАРЧИГ

Нэг. ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ 3

Хоёр. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ 3

Гурав. АЙМГИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ ДЭРГЭД БАЙГУУЛСАН "ТЕЛЕ КАМЕРЫН ХЯНАЛТЫН ДЭД ТӨВ"-Д НЭВТРҮҮЛЭХ УХААЛАГ ПРОГРАММ ХАНГАМЖ, ВИДЕО УДИРДЛАГЫН СИСТЕМИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА 4

Нэг. ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

1.1. Техникийн үндсэн нөхцөл:

1.1.1. Теле хяналтын системийн нэгдсэн удирдлага, хяналт болон системийн технологийн шийдэл, өргөтгөл суурилуулалтыг техникийн тодорхойлолтын дагуу суурилуулах бөгөөд зөрчсөн тохиолдолд ажлын гүйцэтгэлийг хүлээн авахгүй болно.

1.1.2. Техникийн нөхцөлийн дагуу угсралт, суурилуулалтын ажлыг график хуваарийн дагуу гүйцэтгэж захиалагч байгууллагад актаар хүлээлгэн өгөөгүй тохиолдолд теле хяналтын системийн гэмтэл саатал, доголдлоос үүдэн гарах зардал болон хариуцлагыг Баянхонгор аймгийн "Теле камерын хяналтын дэд төв", аймгийн худалдан авах ажиллагаа хариуцсан нэгж хариуцахгүй болно.

1.1.3. Шилэн кабелийн дэд бүтцийн ажлыг Харилцаа холбооны зохицуулах хорооноос олгосон "Кабель шугамын угсралт суурилуулалт хийх" тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэх ба худаг сувагчлал, холбооны багана ашиглан гүйцэтгэх тохиолдолд "Мэдээлэл холбооны сүлжээ" төрийн өмчит компаниар техникийн нөхцөл гаргуулах, гэрэлтүүлгийн багана ашиглах бол нутгийн захиргааны байгууллагаас холбогдох зөвшөөрлийг авсан байна.

1.1.4. Цахилгаан тэжээлийн холболтыг гүйцэтгүүлэхдээ холбогдох байгууллагаас зөвшөөрөл авч, гүйцэтгүүлнэ.

1.2. Зураг төсөвт тусгах шаардлагатай стандарт, журам:

1.2.1. Монгол Улсын стандарт MNS6423:2019 "Теле хяналтын системийн техникийн ерөнхий шаардлага"-ыг хангасан байна.

1.2.1. Шилэн кабелын MNS5207:2011, MNS5276:2013, MNS5277:2003, MNS5278:2012, MNS5280:2003, MNS5281:2003, MNS5317:2011, MNS6544:2015, MNS6597:2016 стандартуудыг хангасан байна.

1.3. Ажил хүлээж авахад бүрдүүлэх материал:

1.3.1. Ажил гүйцэтгэлийн зураг;

1.3.2. Ажлын гүйцэтгэлийн тайлан /ил, далд ажлын зурагтай/;

1.3.3. Шилэн кабелын техникийн акт;

1.3.4. Тоног төхөөрөмжийн жагсаалт, үзүүлэлт, гарын авлага;

1.3.5. Шилэн кабелын дамжуулалт, холболтын зураг /Google earth программ дээр KMZ өргөтгөлөөр, тоног төхөөрөмжийн мэдээллийн хамт/;

1.3.6. Цахилгаан тэжээлийн кабелын дамжуулалт, холболтын зураг /Google earth программ дээр KMZ өргөтгөлөөр, тоног төхөөрөмжийн мэдээллийн хамт/;

1.3.7. Цэгүүдийн байршлын мэдээлэл /Google earth программ дээр KMZ өргөтгөлөөр, тоног төхөөрөмжийн мэдээллийн хамт/;

1.3.8. Ажил хүлээн авах комиссын акт;

Хоёр. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Тоног төхөөрөмжүүд нь стандартын дагуу суурилуулагдана.

2.2. Тоног төхөөрөмжүүдийг байнгын болон найдвартай цахилгаан тэжээлийн болон сүлжээний эх үүсвэрт холбосон байна.

2.3. Систем, техник тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацаа.

- Теле хяналтын системд ашиглагдаж байгаа техник хэрэгслүүд нь 1 жил болон түүнээс дээш хугацаатай үйлдвэрлэгчийн баталгаатай байна;

2.4. Сүлжээний замчлагч болон үндсэн төхөөрөмжүүд нь мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, сүлжээний оролтуудыг хааж, нээн хязгаарлах боломжтой, төхөөрөмж байна.

2.5. Хяналтын камер, тоног төхөөрөмжүүдийн сүлжээний хаягжилт /IP/-ыг Баянхонгор аймагт одоо ашиглагдаж байгаа теле хяналтын сүлжээний хаяглалтын төлөвлөлттэй уялдуулан зохион байгуулна.

2.6. Бусад:

2.6.1. Нийлүүлэгч нь нийлүүлсэн тоног төхөөрөмжийн гэмтлийг баталгаат хугацаанд бүрэн хариуцна.

2.6.2. Нийлүүлсэн тоног төхөөрөмжүүдийг захиалагчийн байранд суурилуулж 72 цаг тасралтгүй ажиллуулан шалгасны дараа хүлээлгэн өгнө.

2.6.3. Суурилуулах бүх төхөөрөмж нь 220В, 50Гц±5% хүчдэлд ажилладаг байхаар сонгоно.

2.6.4. Теле камерын болон сүлжээний тоног төхөөрөмжүүд нь 7/24/365 байнгын тасралтгүй ажиллах зориулалттай байхаар сонгоно.

2.6.5. Техникийн тодорхойлолтод заагдсан тоног төхөөрөмжийн үзүүлэлттэй дүйцэх буюу түүнээс илүү байж болно.

2.7. Олон улсын чанарын шаардлага хангасан тоног, төхөөрөмжүүд байна.

2.8. Цэгт суурилуулсан тоног төхөөрөмжийн жагсаалт, сүлжээний болон цахилгааны холболтын ажлын зургийг гаргаж акт үйлдэж баримтжуулна.

2.9. Нийлүүлэгч болон угсралт суурилуулалтын ажлыг гүйцэтгэх аж ахуй нэгж байгууллага нь инженертэй байна.

2.10. Нийлүүлэгч болон угсралт суурилуулалтын ажлыг гүйцэтгэх аж ахуй нэгж байгууллага нь өөрийн засварын төвтэй байна.

2.11. Сүлжээний үндсэн болон салаалагч, замчлагч /router/ төхөөрөмжийн албан ёсны борлуулагч байна.

2.12. Инженер техникийн ажилтнууд нь мэргэшүүлэх зэргийн туршлагатай байна.

2.13. Гудамж, зам, талбайд суурилуулсан хяналтын камеруудыг “Теле камерын хяналтын дэд төв”-тэй холбож, бичлэг хадгалах төхөөрөмжид холбоно.

Гурав. АЙМГИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ ДЭРГЭД БАЙГУУЛСАН “ТЕЛЕ КАМЕРЫН ХЯНАЛТЫН ДЭД ТӨВ”-Д НЭВТРҮҮЛЭХ УХААЛАГ ПРОГРАММ ХАНГАМЖ, ВИДЕО УДИРДЛАГЫН СИСТЕМИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

3.1. Аймгийн нутаг дэвсгэрийн гудамж, зам, талбайд суурилуулж байгаа хяналтын камеруудыг бичлэг хадгалах төхөөрөмж /NVR/-д холбож, бичлэгийг хадгалах бөгөөд бичлэгийн төхөөрөмжүүдийг видео удирдлагын нэгдсэн системээс зохион байгуулах, хэрэглэгчийн эрх, аюулгүй байдлыг хангахаар зохион байгуулна.

3.2. Видео удирдлагын нэгдсэн систем болон ухаалаг программ хангамжийн систем нь албан ёсны программ хангамж байх бөгөөд тухай аймгийн нутаг дэвсгэрт суурилуулсан болон шинээр суурилуулах камеруудыг дэмжиж ажиллах, нэг удаагийн лицензтэй байна.

3.3. Ухаалаг программ хангамжийн системийн техник хэрэгсэл лицензийн шийдэл нь Монгол улсад өмнө нь туршигдсан, цагдаагийн байгууллагад хүлээн зөвшөөрөгдсөн шийдэл байх, Цагдаагийн ерөнхий газар болон Нийслэлийн Замын хөдөлгөөний удирдлагын төвийн нэгдсэн системтэй холбогдож, харилцан мэдээлэл солилцож ажилладаг байна.

3.4. Видео удирдлагын сервер нь Баянхонгор аймгийн төв Баянхонгор суманд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж болон гудамж зам талбайд суурилуулагдсан теле камеруудыг нэгтгэн ханан дэлгэцэнд харуулах байдлаар зохион байгуулна.

ВИДЕО УДИРДЛАГЫН СИСТЕМ

Видео удирдлагын нэгдсэн систем нь:

- Бичлэг хадгалах сервер компьютер дараах үйлдлийн системүүдийн дор хаяж аль нэгийг дэмждэг байх: Windows, Ubuntu Linux, ARM/Debian Linux.
- Клиент компьютер дараах үйлдлийн системүүдийн дор хаяж аль нэгийг дэмждэг байх: Windows, Ubuntu Linux, Mac OS.
- Кибер аюулгүй байдлын өндөр нууцлалтай байх.
- Системд нэвтрэхэд 2FA буюу давхар нууцлал шаарддаг байх.
- Холболт, нөхцөлт үйлдэл, дүрсний урсгал, өгөгдөл болон бичлэгийг шифрлэн нууцлал хийх боломжтой байх.
- Видео ханыг алс зайнаас удирдаж тохируулах боломжтой байх.
- Нэмэлт ухаалаг программ хангамжуудыг дэмждэг байх.
- Нэмэлт хөгжүүлэлт хийх боломжтой тэр нь нээлттэй байх.
- NVR болон сүлжээний интерфэйстэй DVR төхөөрөмжийг нэмэх боломжтой байх.
- USB веб камер дэмждэг байх.
- Программын хамгийн сүүлийн үеийн бүх шинэчлэлтийг хязгааргүй хугацаанд үнэгүй авч байх боломжтой байх.
- Бичлэг хадгалах үйл ажиллагаа хэзээ ч зогсох ёсгүй ба тусгай төв удирдлагын сервер, алдааны сервер хэрэглэх шаардлагагүй байх. Серверүүд өөрсдөө эдгээр үүргийг зохион байгуулах боломжтой байх.
- Нэг камерын дүрсийг олон жижиг хэсэгт хувааж тус тусдаа цонхонд харуулах боломжтой байх.
- Камерын дүрс дээрээс сонгосон талбарын бичлэгийг богино хугацаанд шүүж харуулдаг функцтэй байх.
- IOT боломж - Камерын дүрс дээр виртуал мэдгэгч тохируулах боломжтой байх. Жишээ нь: Тухайлсан хэсэгт хөдөлгөөн гарахад гэрэл асах, түгшүүрийн дохио ажиллуулах г.м
- AD / LDAP дэмждэг байх
- Сонгосон бичлэгт тэмдэглэгээ оруулж түгждэг байх
- Монголд Улсад албан ёсны эрхтэй борлуулагч байх ба гэрчилгээ шаардана.
- Санал болгож буй системийг цагдаагийн хэрэглэж туршсан байх.
- "Теле камерын хяналтын дэд төв"-д ашиглаж байгаа бичлэг хадгалах төхөөрөмж /NVR/-ийг удирдаж зохион байгуулах, хэрэглэгчийн эрх, хандалтыг зохицуулдаг байна.

№	Тоног төхөөрөмжийн нэрс	Үзүүлэлт	Тоо ширхэг
1.	Видео удирдлагын системийн лиценз	NX Witness Лиценз VMS	67
2.	Rack Server	Dell R760 12*3.5/Silver 4509Y*1/32G RDIMM 5600*1/600G SAS 10K*1/800W*1/57414DP 10GB25GB OCP3.0/IDRAC 9 /rails/raid H355 H.265	1
3.	Hard disk	Seagate Skyhawk AI 20TB 7200 RPM 3.5" Internal Hard Drive ST20000VE002 /5MP-ын 256 камер 30 хоног хадгала	6
4.		SSD Transcend /TS256GSSD230S/	2

ТӨСВИЙН ТОВЧОО

Д/д	Зардлын нэр	Нийт
1.	67 КАМЕРЫН ЛИЦЕНЗТЭЙ ВИДЕО УДИРДЛАГЫН СИСТЕМИЙН НЭВТРҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ ЗАРДАЛ	**70,039,000**
2.	АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ЗАРДАЛ	**9,960,000**
БҮГД ДҮН /төгрөг/		**79,999,000**

БОЛОВСРУУЛСАН:
ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН АХЛАХ ИНЖЕНЕР
ЦАГДААГИЙН ХОШУУЧ Г.МӨНГӨНСҮХ

ХЯНАСАН:
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ШУУРХАЙ УДИРДЛАГЫН ТАСГИЙН
ДАРГА, ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА Г.АЛТАНБАГАНА

.....

оОо